



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 5/90

Чингис хот

Сахилгын шийтгэл оногдуулах тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.2, 81.7 дахь заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/120 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын даргын тушаал гаргах журам /код-136/"-ын 136.4.2-ын "б" заалт, 136.5.2-ын "г" заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар батлагдсан "Сахилгын шийтгэл оногдуулах журам /код-914/"-ын 914.3.1 дэх заалт, Цагдаагийн газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 07-ний өдрийн ээлжит 14 дүгээр зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Биндэр сум дахь сум дундын цагдаагийн тасгийн Дадал сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Н.Гэрэлт-Од нь гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг удаа дараа дарагдуулсан, ажлын байрны тодорхойлолтод заагдсан үндсэн ажлаа хангалтгүй хэрэгжүүлж, гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг заавал хүлээж авах ЭБШХ-ийн 170 дугаар зүйл, гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хянан үзээд гаргах шийдвэр ЭБШХ-ийн 172 дугаар зүйл, ЭБШХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1, 16 дугаар зүйлийн 16.1, 28 дугаар зүйлийн 28.2.12-д заалт, Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.5 дахь заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 12 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь заалтыг тус тус зөрчсөн байх тул цагдаагийн дэслэгч Н.Гэрэлт-Одын албан тушаалын цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хувь бууруулах сахилгын шийтгэл оногдуулсугай.

2. Сахилгын зөрчил дутагдал гаргасан цагдаагийн дэслэгч Н.Гэрэлт-Одод Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.7 дахь заалтыг үндэслэн төлбөртэй сургалтанд хамруулж, дахин зөрчил дутагдал гаргахгүй байх чиглэлээр баталгаа авч, холбогдох хууль, дүрэм, журмуудыг өөрөөр нь судлуулах, үр дүнг тооцох, хариуцсан алба хаагч нартаа бүртгэлээр тавих хяналт, шалгалтыг тогтмолжуулах,

сум дундын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Г.Отгонжаргалд үүрэг болгосугай.

3.Сахилгын арга хэмжээ авагдсан цагдаагийн дэслэгч Н.Гэрэлт-Одын албан тушаалын үндсэн цалинг заасан хувиар хасаж олгохыг ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ж.Баатарт зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн хошууч Т.Чинбаатарт даалгасугай.

5.Тушаалыг нийт бүрэлдэхүүнд танилцуул.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Ж БОЛД

